



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/235

Чингис хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Жонжигжавын Чулуунбатын эзэмшлийн Хэрлэн сумын 3 дугаар баг, С-78 дугаар байрны хойд талд байрлах, гаражийн зориулалттай 77 м<sup>2</sup> газраас иргэн Монхоодойн Наранцэцэгт 25 м<sup>2</sup>, Сүхбаатарын Оюунцэцэгт 26 м<sup>2</sup> газрыг тус тус 32 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Иргэн Ж.Чулуунбат, М.Наранцэцэг, С.Оюунцэцэг нарын эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Ж.Чулуунбат, М.Наранцэцэг, С.Оюунцэцэг нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны 297 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

